

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЗАР

2024 оны 3 дугаар сарын 20

Мандалговь хот

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- ✓ төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх

Бүрдүүлэх материал:

- ✓ Төрийн албан хаагчийн анкет;
- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ✓ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- ✓ Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- ✓ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ✓ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- ✓ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ✓ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/

Материал хүлээн авах:

- ✓ Хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 17.00 цаг хүртэл

Хүлээн авах хаяг:

- ✓ Ажлын байр зарласан байгууллага тус бүрийн цахим хаягаар хүлээн авна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

2024 оны 3 дугаар сарын 20

Мандалговь хот

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага				Хүсэлт ирүүлэх байгууллагын цахим хаяг, утасны дугаар
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	
1	Хулд сумын ЗДТГ	-	ЗДТГ-ын дарга	1	Удирдах	ТЗ-5	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Эрх зүй /042/ Төрийн удирдлага /041303/ Боловсрол /011/ Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэл зүй /08/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ Нийгмийн шинжлэх ухаан /03/ Мэдээлэл, харилцаа холбооны технологи /061/ Хүрээлэн буй орчин /052/ Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх	huld@dundgovi.gov.mn Холбоо барих утас 89008502
2	Хулд сумын ИТХ	-	Нарийн бичгийн дарга	1	Удирдах	ТЗ-5	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	Эрх зүй /042/ Боловсрол /01/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ Хүмүүнлэг /022/ Бизнес ба удирдахуй /041/ Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэл зүй /08/ Нийгмийн шинжлэх ухаан /03/ Мэдээлэл харилцаа холбооны технологи /06/ Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт /07/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх	itkh@khuld.du.gov.mn Холбоо барих утас 88224052

3	Өлзийт сум	-	Засаг даргын Тамгын газрын дарга	1	Удирдах	T3-5	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Эрх зүй /042/ Төрийн удирдлага /041303/ Боловсрол /011/ Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэл зүй /08/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ Нийгмийн шинжлэх ухаан /03/ Мэдээлэл, харилцаа холбооны технологи /061/ Хүрээлэн буй орчин /052/ Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх	www.ulziit.du.gov.mn Холбоо барих утас: 88402208
4	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар	Худалдан авах ажиллагааны газар	Газрын дарга	1	Удирдах	T3-4	Бакалавр болон түүнээс дээш	Эрх зүй 042/ Эдийн засаг /0311/ Бизнес ба удирдахуй /041101, 041301-041307/ Мэдээлэл харилцаа холбооны технологи /061/ Инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /071/ Архитектур ба барилга угсралт /073/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6 -оос доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил, худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	info@dundgovi.gov.mn Холбоо барих утас: 70592548, 70592362
5	Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газар	Биеийн тамир, спортын газар	Газрын дарга	1	Удирдах	T3-4	Бакалавр болон түүнээс дээш	Багш, биеийн тамирын боловсрол /011437/ Биеийн тамирын боловсрол /011438/ Спортын дасгалжуулагч /101401/ Биеийн тамирын арга зүйн /101402/ Эрх зүй /042/ Төрийн удирдлага /041316/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6 -оос доошгүй жил ажилласан байх	info@dundgovi.gov.mn Холбоо барих утас: 70592548, 70592362

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХ САЛБАР ЗӨВЛӨЛ